



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН НЭР: СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
2024–2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

Аудитын код: ДА-2026/06/ҮА

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	1
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	2
Ерөнхий мэдээлэл	3
Аудитын үр дүн	3
Аудитаар илрүүлсэн асуудлууд	4–7
Илрүүлсэн зөрчил	8
Дүгнэлт	8
Зөвлөмж	9

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчлол	Тайлбар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн Өмчийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СХДАГ	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.2.10, 69 дүгээр зүйлийн 69.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 8 дугаар зүйлийн 8.1.1, "Дүрэм батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм", Дотоод аудитын хорооны 2026 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан Дотоод аудитын 2026 оны төлөвлөгөө, хуваарь.
Аудитын зорилт:	Сэлэнгэ аймгийн Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагаа нь төрийн үйлчилгээний чанар, хууль тогтоомжийн хэрэгжилт болон төсвийн үр ашигтай явагдаж байгаа эсэхийг магадлан шалгаж, эрсдэлийг илрүүлэх замаар удирдлагыг бодит мэдээллээр хангахад оршино.
Аудитын хамарсан хүрээ:	Сэлэнгэ аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2024–2025 оны үйл ажиллагаа.
Аудитын арга зүй:	Аудитыг дотоод аудитын олон улсын стандартууд болон Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар баталсан Улсын салбарын дотоод аудитын аргачлалын дагуу нотлох баримт цуглуулж, баримтжуулан, дүн шинжилгээ хийх, харьцуулалт, түүвэрлэлт, ажиглалт ба ярилцлагын арга зүй ашиглан дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.
Аудитын шалгуур үзүүлэлт:	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Авлигын эсрэг хууль,

	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль, Засгийн газрын 2012 оны 134, 2023 оны 301 дүгээр тогтоол, орон нутгийн өмчтэй холбоотой аймгийн ИТХ-н тогтоол, журам.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын санхүүгийн хяналт шалгалтын мэргэжилтэн Б.Идэрчулуун, дотоод аудитор Х.Батбаатар нар гүйцэтгэв.
Тайлангийн хэрэглэгч:	Сэлэнгэ аймгийн Засаг дарга, Дотоод аудитын хороо, Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын дарга, ажилтнууд.

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Газрын чиг үүрэг, бүтэц, орон тооны өөрчлөлт

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар нь Төрийн болон орон нутгийн өмчтэй холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газар болон Төрийн өмчийн хорооноос гарсан журам, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тус газар нь 2010 онд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор анх байгуулагдаж, Засгийн газрын 2016 оны 09 дүгээр тогтоолоор худалдан авах ажиллагааны албатайгаар өөрчлөгдөн байгуулагдсан.

Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 312 дугаар тогтоол, мөн аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/587 дугаар захирамжаар байгууллагын зорилго, зорилт, чиг үүрэгт өөрчлөлт орсны дагуу 12 орон тоотойгоор шинээр байгуулагдсан боловч өнөөдрийн байдлаар төсөв санхүүгийн болон хүний нөөцийн нийлүүлэлтийн бэрхшээлээс шалтгаалан 7 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 527 дугаар тогтоолоор албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулсан байна.

ОНӨГ нь үндсэн чиг үүргийн хүрээнд жил бүр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийн хөдөлгөөн өөрчлөлтийн мэдээ, санхүүгийн тайланг хүргүүлж баталгаажуулдаг.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2025.01.14-ний өдөр аймгийн Засаг даргатай байгуулсан "Хуульд заасан төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн гүйцэтгэх гэрээ"-ний 2.3 дахь хэсэгт ОНӨААТҮГ-уудын үр ашиг, засаглалыг сайжруулах 9 заалт орсон бөгөөд эдгээрийг 100.0% хэрэгжүүлсэн гэж тайлагнасан байна.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.2, 77.3 дахь хэсэгт заасны дагуу аймгийн ИТХ-аар төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагуудын

илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгийн асуудлыг хэлэлцүүлж өмч хөрөнгийг актлах, балансаас балансад шилжүүлэх, дуудлага худалдаагаар худалдах тухай 2024 онд 7, 2025 онд 6, нийт 13 тогтоол гаргуулж хэрэгжилтийг ханган ажилласан байна.

ОНӨГ-н 2024-2025 онд өмч эзэмшүүлэх гэрээ, орон нутгийн өмчийн түрээсийн орлого, дуудлага худалдаанаас орсон орлогын мэдээлэл.

Үзүүлэлт	2024 он	2025 он
Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулсан байгууллагын тоо	216	216
Гэрээ дүгнэсэн хувь	100.0%	95.0%
Орон нутгийн өмчийг түрээсээр бусдад ашиглуулж буй сум, байгууллагын тоо	10 сумын 21 байгууллага	10 сумын 60 байгууллага
Түрээсийн орлогын 20%, төрийн санд төвлөрүүлсэн дүн (мян.төг)	27,693.4	29,210.6
Дуудлагын худалдаагаар орсон орлого, төрийн санд төвлөрүүлсэн дүн (мян.төг)	139,177.6	55,482.7

2. АУДИТЫН ҮР ДҮН

Аудитаар ОНӨГ-ын дотоод хяналтын тогтолцоонд тогтвортой ажилладаг хяналтын механизм бүрдээгүй болохыг тогтоов. Эрсдэл хяналтын матрицад (АБ-2003) тусгасан 9 эрсдэлийн хувьд одоогоор мөрдөгдөж буй хяналт бодитоор хэрэгжээгүй буюу үр нөлөөгүй гэж үнэлэгдсэн тул бүх 9 эрсдэлийг илэрсэн асуудлын нэгтгэлд оруулав.

Эрсдэлийн гүйцэтгэлийн үнэлгээгээр (АБ-3001) нийт 9 шалгуурын дундаж үнэлгээ 13.0 буюу "дунд эрсдэлтэй" бүсэд хамаарч байна.

Илэрсэн асуудлын нэгтгэлээр (АБ-3002, АБ-3002а) нийт 9 асуудал илэрснээс зөрчлийн нийт дүн 103,664 мянган төгрөг байна. Үүнээс 5 асуудлаар нийт 103,664 мянган төгрөгийн зөрчлийг албан шаардлагаар шийдвэрлэж, 4 асуудлаар зөвлөмж хүргүүлэв.

3. АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АСУУДЛУУД

Аудитын явцад тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, гүйцэтгэлийн үнэлгээ, ашиг сонирхлын зөрчил, нийтийн мэдээллийн ил тод байдал, түрээс, хөдөлмөрийн харилцаа, шилэн дансны чиглэлээр нийт 9 асуудал илрүүлсэн бөгөөд асуудал тус бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг доор үзүүлэв.

Илэрсэн асуудал 1: Дуудлага худалдаагаар борлуулсан авто машины үнийн дүнг буцаан олгосон	
Асуудлын ангилал:	Нөлөө их
Бодит байдал:	Дуудлага худалдаагаар худалдан борлуулж, худалдах, худалдан авах гэрээ байгуулсан авто машины үнийн дүнг худалдан авагчид буцаан олгосон.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.4, 40.2.5, 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, 43.3-т заасны

	дагуу дуудлага худалдаанд ялсан оролцогч нь үнийн дүнг хуульд заасан хугацаанд төлж, гэрээний үүргийг бүрэн биелүүлсэн байх.
Үндсэн шалтгаан:	Ажлын хэсгийн гишүүдийн хуулийн мэдлэг дутмаг, дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй байсан нь гэрээг хүчингүй болгоход хүргэсэн.
Байгууллагад үзүүлэх нөлөө:	Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ буурч, дуудлага худалдаанд оруулах эд хөрөнгийн доод үнэлгээг дараагийн худалдаанд бууруулах эрсдэл үүсэж байна.
Аудитын шийдвэрлэлт:	Цаашид худалдах, худалдан авах гэрээний биелэлтийг бүрэн хангуулах талаар хүргүүлэв. АЛБАН ШААРДЛАГА

Илэрсэн асуудал 2: Аймгийн ИТХ-ын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 30 дугаар тогтоолын хэрэгжилт бүрэн хангагдаагүй

Асуудлын ангилал:	Нөлөө бага
Бодит байдал:	Орхон сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй авто машиныг акталсан эсэхийг баталгаажуулах бүртгэл, тайлан байхгүй; Орхон бүсийн ойн ангийн тракторыг актлан борлуулсан тухай тайланд тусгасан боловч борлуулалтын дүн, байршил тодорхойгүй.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Аймгийн ИТХ-ын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 30 дугаар тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж, тайлагнасан байх.
Үндсэн шалтгаан:	Акталсан хөрөнгийн бүртгэл, тайлагналын дотоод журам нэвтрүүлэгдээгүй, хяналт болон хариуцлагын тогтолцоо дутмаг.
Байгууллагад үзүүлэх нөлөө:	Орон нутгийн өмч хөрөнгийн актлал, борлуулалтын бүртгэл, тайлагналын үнэн зөв, бүрэн байдал алдагдаж, борлуулалтын орлого бүрэн төвлөрсөн эсэхийг хянах боломжгүй болно.
Аудитын шийдвэрлэлт:	ИТХ-с гарсан орон нутгийн өмч хөрөнгийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах талаар хүргүүлэв. ЗӨВЛӨМЖ

Илэрсэн асуудал 3: Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ бодитой бус, баталгаажуулаагүй

Асуудлын ангилал:	Нөлөө дунд
Бодит байдал:	Албан хаагчдад 2024–2025 онуудад улирлын үр дүнгийн урамшууллыг үнэлгээний хуудас болон нотлох баримтгүйгээр олгосон.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2023 оны 301 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байх.
Үндсэн шалтгаан:	Гүйцэтгэлийн үнэлгээний журмын хэрэгжилтийг хангах дотоод хяналтын механизм байхгүй, удирдлагын хяналт хангалтгүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө:	Урамшуулал бодит гүйцэтгэлд үндэслэлгүйгээр олгогдсоноос төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, гүйцэтгэлийн үнэлгээний шударга байдал алдагдах эрсдэлтэй.

Аудитын шийдвэрлэлт:	Цаашид урамшуулал олгохдоо гүйцэтгэлийн үнэлгээний хуудас, нотлох баримтыг бүрдүүлж, холбогдох журмын хэрэгжилтийг хангах талаар хүргүүлэв. АЛБАН ШААРДЛАГА
-----------------------------	--

Илэрсэн асуудал 4: Ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн

Асуудлын ангилал:	Нөлөө их
Бодит байдал:	Газрын дарга нь дээд шатны эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр өөртөө тушаал гаргаж, улирлын үр дүнгийн урамшуулал олгосон.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйл 11.1 Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно
Үндсэн шалтгаан:	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх дотоод журам болон хяналтын тогтолцоо бүрдээгүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө:	Удирдлагын шийдвэрийн шударга байдал алдагдаж, ашиг сонирхлын зөрчил үүсэх, байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.
Аудитын шийдвэрлэлт:	Цаашид урамшуулалтай холбоотой шийдвэрийг эрх бүхий байгууллагаар баталгаажуулж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар хүргүүлэв. АЛБАН ШААРДЛАГА

Илэрсэн асуудал 5: Нийтийн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт хангалтгүй

Асуудлын ангилал:	Нөлөө бага
Бодит байдал:	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг дуудлага худалдаагаар борлуулах зар мэдээллийг зөвхөн нэг хэвлэлийн эрхлэгчээр дамжуулан мэдээлсэн.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн холбогдох заалтын дагуу мэдээллийг олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байдлаар хүргэсэн байх.
Үндсэн шалтгаан:	Ил тод байдлыг хэрэгжүүлэх дотоод журам, хяналтын механизм болон ажилтнуудын мэдлэг дутмаг.
Байгууллагад үзүүлэх нөлөө:	Өрсөлдөөнт оролцоо хязгаарлагдаж, өмчийн хөрөнгийг зах зээлийн үнээс доогуур борлуулах эрсдэл нэмэгдэнэ.
Аудитын шийдвэрлэлт:	Дуудлага худалдааны мэдээллийг олон сувгаар түгээж, ил тод байдлын хуулийн шаардлагыг хангаж ажиллах талаар хүргүүлэв. ЗӨВЛӨМЖ

Илэрсэн асуудал 6: Түрээсийн доод үнийг мөрдөөгүй

Асуудлын ангилал:	Нөлөө бага
--------------------------	-------------------

Бодит байдал:	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэхдээ аймгийн ИТХ-ын тогтоолоор тогтоосон доод үнийг мөрдөөгүй.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Сэлэнгэ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 25 дугаар тогтоолын хавсралтаар баталсан түрээсийн доод үнийг бүрэн мөрдсөн байх.
Үндсэн шалтгаан:	Гэрээний менежментийн дотоод хяналт сул, тогтоолын хэрэгжилтийг хангах тогтолцоо бүрдээгүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө:	Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ буурсан.
Аудитын шийдвэрлэлт:	Цаашид түрээсийн гэрээ байгуулахдаа батлагдсан доод үнийг бүрэн мөрдөж ажиллах талаар хүргүүлэв. ЗӨВЛӨМЖ

Илэрсэн асуудал 7: Түрээсийн гэрээний мэдээллийг буруу тусгасан, гэрээний хэрэгжилтэд хяналт, мониторинг хийдэггүй

Асуудлын ангилал:	Нөлөө дунд
Бодит байдал:	Түрээсийн гэрээнд талбайн зориулалт, үнийг буруу тусган гэрээ байгуулсан, гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт, мониторинг хийж дүгнэлт гаргадаггүй
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 "Түрээсийн гэрээнд Иргэний хуулийн 105 дугаар зүйлд заасан нөхцөлөөс гадна эд хөрөнгө түрээслүүлэх хугацаа, төлбөр, нөхцөл, хугацаанаас өмнө цуцлах үндэслэл, үүсэх үр дагавар, түүнийг арилгах журмыг заавал тусгана, Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн "Орон нутгийн эд хөрөнгийг түрээслэх журам, түрээсийн төлбөрийн хэмжээг батлах тухай" 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт 2.3 "Орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлэхдээ түрээслүүлэгч, түрээслэгч талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг хууль тогтоомжийн дагуу тодорхойлж, түрээсийн төлбөрийн хэмжээ, төлөх хугацаа, хэлбэр, торгууль оногдуулах журам, төлбөр барагдуулахтай бусад зүйлийг гэрээнд тусгасан байна
Үндсэн шалтгаан:	Гэрээний баталгаажуулалтын тогтолцоо, стандарт загвар байхгүй, хяналт, мониторинг болон хариуцлагын механизм байхгүй ажилтнуудын мэдлэг хангалтгүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө:	Гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан үүсэх, гэрээний үүргийн биелэлт алдагдах, орлого тасалдах, өмчийн ашиглалт үр ашиггүй болох эрсдэлтэй..
Аудитын шийдвэрлэлт:	Гэрээний стандарт загвар боловсруулж, давхар хяналтын тогтолцоог нэвтрүүлэх, гэрээний хэрэгжилтийг жил бүр үнэлж тайлагнах тогтолцоог бий болгох талаар хүргүүлэв. АЛБАН ШААРДЛАГА

Илэрсэн асуудал 8: Цагийн бүртгэлгүйгээр цалин олгосон

Асуудлын ангилал:	Нөлөө бага
Бодит байдал:	2024–2025 онд албан хаагчдын ажлын цагийн бүртгэлгүйгээр цалин бодож олгосон.

Байх ёстой шаардлага /шалгуур/:	Хөдөлмөрийн тухай хууль болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу цагийн бүртгэлийг тогтмол хөтөлсөн байх.
Үндсэн шалтгаан:	Цагийн бүртгэл болон цалин тооцооны хоорондын хяналтын тогтолцоо бүрдээгүй, хариуцсан ажилтан тодорхойгүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө:	Цалин хөлсийг буруу тооцох, төсвийн хөрөнгийг үндэслэлгүй зарцуулах эрсдэлтэй.
Аудитын шийдвэрлэлт:	Цагийн бүртгэлийг тогтмол хөтөлж, цалин бодолтыг бүртгэлтэй уялдуулах талаар хүргүүлэв. ЗӨВЛӨМЖ

Илэрсэн асуудал 9: Шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулаагүй

Асуудлын ангилал:	Нөлөө дунд
Бодит байдал:	2024–2025 онд гарсан 19 тушаал болон 5 төрлийн мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Шилэн дансны тухай хуулийн 6.4.8, 7.1-д заасан мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байх.
Үндсэн шалтгаан:	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, хариуцсан ажилтан болон удирдлагын хяналт сул.
Байгууллагад үзүүлэх нөлөө:	Ил тод байдал алдагдах, иргэдийн мэдээлэл авах эрх зөрчигдөх, хуулийн хариуцлага хүлээх эрсдэлтэй.
Аудитын шийдвэрлэлт:	Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн байршуулж, дотоод хяналтыг сайжруулах талаар хүргүүлэв. АЛБАН ШААРДЛАГА

4. ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Сэлэнгэ аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2024–2025 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитаар нийт **103,663.6** мянган төгрөгийн мөнгөн дүн бүхий **9** асуудал илэрлээ. Үүнээс санхүүгийн хяналт шалгалтын байцаагчийн **5** асуудлаар нийт **103,663.6** мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох **АЛБАН ШААРДЛАГА**, **4** асуудлаар дотоод хяналтын сайжруулалтыг шаардсан **ЗӨВЛӨМЖ** хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Нийтлэг шалтгааны дүн шинжилгээ

Илэрсэн асуудлуудын нийтлэг шалтгаан нь дараах байна:

- Дотоод хяналтын тогтолцоо хангалттай бүрдээгүй — 9 асуудлын бүгдэд давтагдсан;
- Батлагдсан журам, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих механизм сул — 7 асуудалд нөлөөлсөн;
- Хариуцсан ажилтнуудын эрх зүйн мэдлэг, ур чадвар дутмаг — 5 асуудалд нөлөөлсөн;
- Тайлагнал, бүртгэл, мэдээллийн тогтолцоо бүрдээгүй — 4 асуудалд нөлөөлсөн;

- Удирдлагын хяналт, хариуцлагын тогтолцоо хангалтгүй — 6 асуудалд нөлөөлсөн.

5. ДҮГНЭЛТ

Аудитын үр дүнгээс үзэхэд Сэлэнгэ аймгийн Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагаанд тогтмол ажилладаг дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй байна. Илэрсэн 10 асуудлын үндсэн шалтгааны шинжилгээгээр (АБ-3000) дараах нийтлэг дутагдлууд давтагдаж байна:

- ✓ Орон нутгийн өмч хөрөнгийг актлах, борлуулах, түрээслэх үйл ажиллагааны дотоод журам болон гэрээний стандарт загвар байхгүй буюу хэрэгжихгүй байна;
- ✓ Албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээ, урамшуулал олгох, ажлын цагийн бүртгэлтэй холбоотой журмын хэрэгжилтэд хяналт тавьдаггүй;
- ✓ Удирдлагын шийдвэрийг дээд шатнаас баталгаажуулах, давхар хянах механизм байхгүйгээс ашиг сонирхлын зөрчил үүсч байна;
- ✓ Нийтийн мэдээллийн ил тод байдал болон Шилэн дансны тухай хуулийн үүргийн биелэлт хангалтгүй, хариуцсан ажилтан тодорхойгүй.

Дээрх дутагдлуудын нийтлэг үндэс нь холбогдох ажилтнуудын хууль, журмын мэдлэг дутмаг, дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй, удирдлагын зүгээс хяналт хангалтгүй байгаатай шууд холбоотой.

Иймд Сэлэнгэ аймгийн Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааг **“Сайжруулах шаардлагатай”** гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Сайжруулах шаардлагатай	Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь 2-р түвшин (давтамжтай)-д байна гэж үзэв. Аудитаар нийт 9 асуудал илэрснээс 5 нь албан шаардлага шаардсан буюу нийт зөрчлийн дүн 103,663.6 мянган төгрөг байна. "Нөлөө ихтэй" ангиллын 2 асуудал, "Нөлөө дунд" ангиллын 3 асуудал, "Нөлөө бага" ангиллын 4 асуудал тус тус тогтоогдлоо.

6. ЗӨВЛӨМЖ

Эрсдэлийн гүйцэтгэлийн үнэлгээгээр (АБ-3001) дундаж үнэлгээ 13.0 буюу **"дунд эрсдэлтэй"** түвшинд байгаа бөгөөд хяналт бодитоор хэрэгжээгүй гэж үнэлэгдсэн нь цаашид эрсдэл нэмэгдэж болзошгүйг харуулж байна. Иймд доорх зөвлөмжийг хугацаатай хэрэгжүүлж, тогтмол хяналт тавьж ажиллахыг үүрэг болгов.

Байгууллагын даргад хүргүүлэх зөвлөмж:

1. ИТХ болон эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг тогтмол хянаж, акталсан хөрөнгийн борлуулалтын бүртгэл, тайлагналын тогтолцоог бүрдүүлж ажиллах.
2. Орон нутгийн өмчийн дуудлага худалдааны мэдээллийг байгууллагын цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон шилэн данс зэрэг олон сувгаар нэгэн зэрэг нийтэд мэдээлж хэвших.

3. Цаашид түрээсийн гэрээ байгуулахдаа Сэлэнгэ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 25 дугаар тогтоолоор баталсан доод үнийг заавал мөрдөж, гэрээ дүгнэлтийг дотоод хяналтаар хянуулах.
4. Ажлын цагийн бүртгэлийг сар бүр тогтмол хөтөлж, цалин бодолтыг бүртгэлтэй уялдуулан хийх; энэ үүргийг хариуцах ажилтныг тодорхой томилх.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ДОТООД АУДИТОР

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
СХШУАБ

ТАНИЛЦСАН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА

Х.БАТБААТАР
Б.ИДЭРЧУЛУУН
Т.ОДСҮРЭН
П.ЭРДЭНЭСАЙХАН